



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 4/МБ.

Улаанбаатар хот

「Баянзүрх дүүргийн 255 дугаар цэцэрлэгийн」 эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 2,304,096.16 (хоёр сая гурван зуун дөрвөн мянга ерэн зургаан төгрөг арван зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн 255 дугаар цэцэрлэг (Г.Цэцгээ)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 5 нэр төрлийн 854,096.16 (найман зуун тавин дөрвөн мянга ерэн зургаан төгрөг арван зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 2 нэр төрлийн 1,450,000.00 (нэг сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгөхийг Баянзүрх дүүргийн 255 дугаар цэцэрлэг (Г.Цэцгээ)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150501230



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 11 дугаар сарын 11-ны өдрийн 111/25 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 255 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн хурлын дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХТ-ын мөргөжлтийн үнийн санал	ҮХХХХК-ын хурлын шийдвэр
1	Угаалгын машин /Mopel-хагас автомат/	5	ш	1	182,447.00	182,447.00	182,447.00	-	Сэлбэг мотор нь шатсан	актлах	актлах	устгах	устгах
2	Угаалгын машин /Home-хагас автомат/	5	ш	1	199,900.00	199,900.00	199,900.00	-	Сэлбэг мотор нь шатсан	актлах	актлах	устгах	устгах
3	Принтер /Epson L-380 өнгөт/	5	ш	1	350,000.00	350,000.00	350,000.00		Шатсан	актлах	актлах	татах	татах
4	Тоос сорогч /Sharp/	5	ш	1	229,900.00	229,900.00	229,900.00		Шатсан, сэлбэг нь олдохгүй	актлах	актлах	устгах	устгах
5	Индүү (Philips)	5	ш	1	139,900.00	139,900.00	139,900.00		Дахин ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
6	Зурагт /TCL-43 инч/	2	ш	1	1,100,000.00	1,100,000.00	440,000.00	660,000.00	Дэлгэцийг нь хүүхэд хагалсан. Оронд нь зурагт авч өгсөн.	актлах	актлах	татах	татах
Машин, тоног төхөөрөмжийн дүн						2,202,147.00	1,542,147.00	660,000.00					
7	Багш сандал	5	ш	2	50,974.58	101,949.16	101,949.16	-	Дахин ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
Тавилга, эд хогшлын дүн						101,949.16	101,949.16	-	-	-	-	-	-
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						2,304,096.16	1,644,096.16	660,000.00					
Үүнээс: Худалдах хөрөнгө													
Устах хөрөнгө						854,096.16	854,096.16						

Татан төвлөрүүлэх хөрөнгө	1,450,000.00	790,000.00	660,000.00			
Худалдсанаас олох орлого						
НӨХГ-г төвлөрүүлэх /30%/						